

Нээлттэй буюу “Электрон засгийн газар” гэж юу вэ?

Засгийн Газрын үйлчилгээг нийтэд хүргэх, засаглалын үйл ажиллагааг явуулах, үүндээ үйлчилгээг хүртэгчид-харилцагчдыг оролцуулах зэрэгт интернэтэд суурилсан үйлчилгээг тулгуур болгон мэдээллийн технологи, холбоог ашиглах замаар улсын секторын дотоод “гадаад” харилцаа, засаглалын үйл ажиллагааг оновчтойгоор шийдвэрлэх, өөрчлөн зохион байгуулах үйл явцыг “Электрон засгийн газар” гэж томъёолдог.

Энэ тодорхойлолт магадгүй дэндүү нүсэр, хүнд сонсогдож байж болох юм. Тэгвэл үүнийг энгийнээр задлан тайлбарлахыг зорьё.

Электрон засгийн газар нь үйлчилгээ хүргэлт, харилцагчдын оролцоо, засаглал гэсэн 3 үндсэн хэсгээс бүрдсэн ерөнхий бүтэцтэй байна. Зураг-1.



Зураг-1. Электрон засгийн газрын ерөнхий бүтэц

1. Үйлчилгээ хүргэлт

Мэдээлэл хэрэглэгчид, харилцагчид нь Засгийн Газрын аливаа мэдээлэлд хүрэхийн тулд “өөрөө өөртөө үйлчлэх” зарчимд тулгуурлана гэдгээ ухамсарласан байдаг. Энэ нь Интернэтэд оршдог ердийн зарчим. Ийм учраас ЗГ нь энэ шинэ нөхцөлд тохируулан үйл ажиллагаагаа бүхэлд нь юмуу хэсгийг нь өөрчлөн зохион байгуулах шаардлагатай юм. Жишээ нь мэдээллээ хэрхэн зохицуулах, бүтэц хэлбэрийг нь тогтоох, төсөвлөх, хариуцах ажилтанг томилох гэх мэт олон асуудлыг шийдэх зорилттой тулгарна. Нэг ёсондоо уламжлалт аргаар явуулж байсан арга хэлбэрээ өөрчилж, үйлчилгээгээ хүргэх шинэ аргачлалыг бий болгоно гэсэн үг юм.

2. Харилцагчдын оролцоо


Жирийн иргэд, бизнес эрхлэгчид нь Засгийн газартай харьцах энгийн бөгөөд дөт, оновчтой арга замыг байнга эрэлхийлж байдаг. Энэхүү харилцаа нь гурван хэлбэртэй байж болно. Үүнд:

1. Мэдээлэл – Засгийн газрын байгууллагын мэдэлд байдаг аливаа мэдээлэлд хүрэх
2. Холбоо тогтоож, харьцах – Ямар нэг асуулт, асуудал тавьж хариуг нь авах буюу шийдвэрлүүлэх
3. Транзакци хийх – Харилцагч талууд ямар нэг бодит үүрэг, хариуцлага харилцан хүлээж, түүнийгээ хэрэгжүүлэх

3. Засаглал

Засгийн газрын гол зорилго бол засаглалын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ хуулийг биелүүлэхэд анхаарах, хуулийн хүрээнд үүргээ гүйцэтгэх явдал байдаг. Электрон засгийн газар нь засаглалыг хэрэгжүүлэх цоо шинэ боломж, нөхцөлийг нээж байна. Гэхдээ энэ нь засгийн газар өөрийнхөө үүрэг роль, харилцагчиддаа хандах хандлагаа шинэ өнцгөөс харж өөрчлөх, аажмаар хувьсах замаар л хэрэгжих бололцоотой юм.

Нээлттэй Засгийн Газрыг байгуулах асуудал нь урт хугацааны төлөвлөлтөөр шийдэгдэх бөгөөд хөгжлийн нэг үе шатнаас нөгөөд гулсан орох замаар явагдана. Энэ үйл явцыг зураглалаар харуулав.



Зураг-2. Электрон засгийн газрыг байгуулах хөгжлийн үе шат

Харин энэ үйл явц дээд шатандаа орох тусам өртөг нэмэгдэж, үйл ажиллагаа нь цар хүрээ нь илүү төвөгтэй нарийн болох боловч үүнийхээ хэрээр харилцагчдад хүрэх үр өгөөж нь илүү үнэ цэнтэй болж, Засгийн газрын үйл ажиллагаа улам ил тод нээлттэй болох механизм бүрэлдэх юм.

Эдгээр үе шат бүр нь өөр өөрийн онцлогтой ч, хөдөлгөгч хүч нь 4 үндсэн элементтэй байна. Энэ нь стратеги бодлого, хүмүүс, үйл ажиллагаа, технологи гэсэн элементүүд юм.



Зураг-3. Хөгжлийн үе шатууд дахь хөдөлгөгч хүчний 4 үндсэн элемент

Дээр дурдсан хөгжлийн буюу хувьслын үе шатуудыг үндсэн элементүүдээр нь задалж үзүүлье. Үүнд:

1-р үе шат буюу Мэдээлэл байршуулах үе:

- Технологи: Вэб сайт байгуулах
- Үйл ажиллагаа: Засгийн газрын зарим үйл ажиллагааг өөрчлөн зохион байгуулах
- Хүмүүс: Одоо байгаа мэргэжилтнүүд дээрээ тулгуурлах
- Бодлого: Нийтээр хүлээн зөвшөөрүүлэх

2-р үе шат буюу Харилцан солилцооны үе:

| | |
|----------------|---|
| Технологи: | Электрон шуудан, хайлтын систем |
| Үйл ажиллагаа: | Өгөгдөл, мэдээллийн синхронизаци хийх, мета өгөгдөл үүсгэх, мэдээллийн агуулгын менежмент, мэдлэгийн менежемент |
| Хүмүүс: | Мэргэжилтэн шинээр бэлтгэх, ажилтнуудыг сургах |
| Бодлого: | Хайлтын боломж бүхий мэдээллийн сан, олон нийтийн хариу захидал, имэйл |

3-р үе шат буюу Солилцоо арилжааны үе:

| | |
|----------------|---|
| Технологи: | Үйлчилгээг гаднаас авах, 24 цаг, 7 хоногийн тасралтгүй үйл ажиллагаатай дэд бүтэц, мэдээллийн хандалт, аюулгүй ажиллагааны систем, хуулийн систем |
| Үйл ажиллагаа: | Онлайн интерфейс, харилцааны менежмент, үйл ажиллагааны өөрчлөн зохион байгуулалт, ре-инженеринг |
| Хүмүүс: | Захиалгаар хийлгэх, бизнест түшиглэх, нэгдсэн менежмент, чадварын өсөлт, өөрөө өөртөө үйлчлэх чадвар |
| Бодлого: | электроноор нэвтрүүлэх боломж, транзакци хийсний төлбөр тооцох, нууцлалыг хадгалах зарчим, өрсөлдөөн |

4-р үе шат буюу Бүрэн шилжилтийн үе:

| | |
|----------------|---|
| Технологи: | Мэдээллийн цоо шинэ бүтэц, шинэ хэрэглээ |
| Үйл ажиллагаа: | Хамтын ажиллагаа, харилцааны (G2G засгийн газар-засгийн газар, G2B засгийн газар-бизнес, G2C засгийн газар-хэрэглэгч, G2E- засгийн газар-ажилтан) шинэ хэлбэр, цогц үйлчилгээ |
| Хүмүүс: | Нийтлэг үйл ажиллагаа, олон талт чадвар, гүйцэтгэлийг тооцох боломж, зайнаас харилцах, ажлын шинэ бүтэц |
| Бодлого: | Байгууллагыг тодорхойлох, санхүүжилтийн урсгалыг зохицуулах, “big browser” |

Электрон Засгийн газар бий болохын давуу тал:

- Засгийн газраас иргэдийн өмнө хүлээх хариуцлагын тогтолцоо бүрдэнэ
- Засгийн газрын мэдээллийг иргэд, байгууллагад хүргэх бололцоо ихэснэ
- Засгийн газрын үйл ажиллагаа оновчтой болж, зардал багасна
- Засгийн газраас үзүүлэх үйлчилгээ хөнгөн шуурхай болно

Электрон Засгийн газрын үйл ажиллагааны энгийн жишээнээс дурдвал:

- Онлайнаар уулзалт хийх, санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэр гаргах
- Онлайн парламентын цаг – Засгийн газрын тусгай цаг, хариуцсан хэвлэл мэдээллийн ажилтантай болох
- Ерөнхийлөгчийн шууд ярилцлага
- Онлайн хуулийн хэлэлцүүлэг

- Үнэгүй имэйл мэдээллийн листүүд, хэлэлцүүлгийн групп бий болгох
- Зөвлөлгөө өгөх
- Нийгмийн халамжийн үйлчилгээний лавлагаа авах
- Санал асуулга, судалгаа явуулах
- Сонгуулийн явцад мэдээ, мэдээлэл, шууд асуулт, хариулт
- Ирээдүйд сонгуульд саналаа электрон аргаар өгч болно.
- Татвараа төлөх, гүйлгээ хийх
- Ерөөсөө Иргэний онлайн амьдралын хэв маяг үүсгэх боломж бүрдүүлэх.

Бусад орны жишээнээс:

- <http://www.govt.nz> - New Zealand Online Government
- <http://www.e-envoy.gov.uk/> - Office of the e-Envoy, UK
- <http://www.irlgov.ie> - Information on Irish State

Б.Наранцэцэг
2001-11-15